

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО, ТӨСВӨӨС
ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН

АУДИТЫН КОД: АГГ-2021/12-ШТА-ГА



Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр

Утас: 70483413

Цахим хаяг: Tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055

Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэнханд

Цахим хаяг: Tserenkhanded@audit.gov.mn

Аудитор Б.Цэвэлмаа

Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn

ТАЙЛАНТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙГ WWW.AUDIT.MN ЦАХИМ ХАЯГААР АВНА
УУ.

АЛТАЙ ХОТ 2021 ОН



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 05 өдөр

Дугаар Н/32

Алтай хот

**Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.



Х.ТҮВШИНБАЯР

Говь-Алтай аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга, тэргүүлэх
аудиторын 2022 оны 11 дугаар
сарын 05-ны өдрийн 132 дугаар
тушаалын хавсралт

8217144139
ДЮА0060 2018301

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

ДД	Хариуцагч	Товч утга	Дугаар	Зөрчлийн дүн /мян.төгрөг/
1	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	01/216, 02/216, 03/216	0
2	Мэргэжлийн хяналтын газар	Зөрчил арилгуулах тухай	04/216, 05/216, 06/216	0
		Төлбөр барагдуулах тухай	01/162	1,755.3
3	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Зөрчил арилгуулах тухай	07/216 08/216	117,711.1
		Төлбөр барагдуулах тухай	02/162	1,496.0
	Нийт дүн			120,962.4

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар
Хүснэгтийн товъёг
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

БҮЛЭГ 1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО ҮР
НӨЛӨӨТЭЙ ЭСЭХ.....6

ДҮГНЭЛТ: ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО ХАНГАЛТГҮЙ
БАЙНА.....

БҮЛЭГ 2. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН
ХӨРӨНГӨ ҮР ДҮНТЭЙ ЭСЭХ

ДҮГНЭЛТ: ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙГААГ ЭС ТООЦВОЛ ГҮЙЦЭТГЭЛ ҮР ДҮНТЭЙ
БАЙНА.....

.....
ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ :26-27
ШИЙДВЭР:28-29
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:30-31
САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:32-33
ХАВСРАЛТУУД:34-36

Товчилсон үгсийн тайлбар

ААН	Аж, ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХС	Мал хамгаалах сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
СХЗХ	Стандарт хэмжил зүйн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБАБХТХ	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХДӨ	Хоол хүнсээр дамжих өвчлөл
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Хүснэгт, дүрслэл, зураг , хавсралтын тайлбар
Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хүнсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд оролцогч талууд, тэдгээрийн чиг үүрэг	10
Дүрслэл 2	Хуулийн шаардлага хангаагүй салбарын зөрчлийн нэгтгэл /Хяналтын хуудсаар 2018-2020 он/	11
Дүрслэл 3	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар илэрсэн зөрчил /тоогоор/	12
Дүрслэл 4	Санал асуулгын үр дүн /хяналтын тогтолцооны талаар/	13
Дүрслэл 5	Санал асуулгын үр дүн /хоолны хордлогын талаар/	14
Дүрслэл 6	Хүнсний эрхийн бичигт хамрагдагч өрхийн тоо /сумаар/	20
Дүрслэл 7	Санал асуулгын үр дүн /бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт/	21
Дүрслэл 8	Санал асуулга /сургалт, сурталчилгаа/	22
Дүрслэл 9	СХС-гаас зээл авсан иргэн, ААНБ-ын зориулалт /салбараар/	24
Хүснэгт 1	Иргэд, ААНБ-аас ирсэн гомдол мэдээлэл	15
Хүснэгт 2	Лабораториудын шинжилгээний дээж, дүнгийн мэдээлэл	19
Хүснэгт 3	Хүнсний салбарын ААНБ-ын тоо, мэдээллийг харьцуулсан судалгаа	21
Хүснэгт 4	Хоол, хүнсний талаарх мэдлэг олгох сургалт, сурталчилгаанд хамрагдалт	23
Хүснэгт 5	Боловсролын салбарын орон тооны стандарт	
Зураг 1	Жижиглэн савласан бүтээгдэхүүнд хаяг шошгын мэдээлэлгүй бүтээгдэхүүн	15
Зураг 2	Хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүн	15
Зураг 3	Үйлдвэрлэсэн огноо тэмдэглээгүй хүнсний бүтээгдэхүүн	15
Зураг 4	Албан тоот /ЗДТГ/	16
Зураг 5,6,7	Шинэ-Алтай захын лабораторийн нөхцөл байдал	17
Зураг 8,9	Шинэ-Алтай зах дээр махны ил задгай худалдаа /2021 оны 10 сарын 12 өдөр/	19
Зураг 10	Албан тоот /Статистикийн хэлтэс/	18
Хавсралт 1	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хяналтын хуудасны нэгтгэл	34
Хавсралт 2	Аймгийн хүнсний хангамжийн тооцоо	35
Хавсралт 3	Хүнсний бүтээгдэхүүн хадгалах зоорины судалгаа	36

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх
мэдэгдэл**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, Улсын Их хурлын болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилгын хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх;
- Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгө үр дүнтэй эсэх;

**Аудитын хамарсан
хүрээ**

Аудитад хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааг зохион байгуулах, бүх түвшинд хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих, мэдээллээр хангах чиг үүрэгтэй төрийн тусгай болон төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудал эрхэлсэн байгууллагууд, ХХААГ, МХГ, ЭМГ, СХЗХ, ТББ, хүнсний сүлжээний бүх үе шатанд оролцогч хуулийн этгээд, иргэний аудитад хамаарал бүхий үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын хугацаанд Ковид-19 халдварын цар тахлын нөхцөл байдлын улмаас сумдад хийгдсэн ажлыг бодитоор үзээгүй болно.

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгов.

Аудитаар холбогдох албан тушаалтнуудтай нээлттэй хэлэлцүүлэг хийх, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, төсөл хөтөлбөрөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үр дүн, Засаг даргын мөрийн хөтөлбөр, Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн биелэлтийг тулган баталгаажуулах, гүйцэтгэлийн төлөвлөгөө биелэлт, бусад шаардлагатай баримт материал, статистик судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын хяналт тавьж стандартыг хангуулан, ахлах аудитор Д.Цэрэнханд, аудитор Б.Цэвэлмаа, гэрээт аудитор Ж.Батцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын төлөвлөгөөг 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн дотор боловсруулан, талбарын ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 26-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл

1. Аудитад хамрагдан шалгагдаж байгаа байгууллагуудын зарим албан тушаалтнууд Ковид-19 өвчний халдвар авч тусгаарлагдсан, албан томилолтоор хөдөө ажилласан.
2. Аудитын нээлтийг цахимаар хийсэн, төлөвлөгөөг хүргүүлсэн байхад МХГ-ын дарга албан тушаалтнуудад мэдээллийг бүрэн хүргээгүйн улмаас аудитад шаардлагатай баримт материалыг дутуу ирүүлэх, албан тушаалтан бүр удирдамж шаардах, баримт материалаа ирүүлэхгүй удаашрах, олон дахин шаардуулж цаг хугацаа их алдсан. Тухайлбал: Гүйцэтгэлийн шат дуусахаас 2 хоногийн өмнө зарим баримт материалыг ирүүлсэн.
3. Аймгийн ЗДТГ, ХХААГ-ын хүнс хариуцсан мэргэжилтэн солигдсонтой холбоотойгоор зарим мэдээлэл дутуу, тодруулга авахад тухайн ажлын талаар мэдэхгүй байлаа.

Үндсэн мэдээлэл

Говь-Алтай аймагт хүнсний бүтээгдэхүүний сорилт, шинжилгээ хийх эрх бүхий МХГ-ын лаборатори ажиллаж байна. Тус лабораториор 2018-2020 онд хими хор судлал, эрүүл ахуй, нян судлал, ургамал хорио цээрийн чиглэлээр 6,110 сорьцод 17,911 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс 349 сорьц стандартын шаардлага хангаагүй, зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр гарсан байна.

Монгол Улсын хэмжээнд хүнсний холбогдолтой үндэсний 668 стандартыг мөрдөж байгаагаас 264 буюу 39.5 хувь нь олон улсын стандартын түвшинд нийцсэн, 404 буюу 60.5 хувь нь уялдуулан боловсруулагдсан байна.

Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2,000,000.0 мянган төгрөгөөр “Газар тариалан, жимс жимсгэнэ” хөтөлбөрийг санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан байна. Тус хөтөлбөрийн хүрээнд алим, жимс жимсгэнэ, бүх төрлийн хүнсний ногоо, үр тариа, малын ногоон тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлж, хүн амыг эрүүл, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр ханган, нутгийн брэнд бүтээгдэхүүнийг шинээр бий болгохоор тусгажээ.

Аймгийн ЭМГ-аас ирүүлсэн 2018-2021 оны хоол хүнсээр дамжих өвчний судалгаагаар хоол хүнсээр дамжих хордлогот халдвар болон халдварт өвчний 27 тохиолдол бүртгэгдсэн байна.

БҮЛЭГ 1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА

1.1 Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын зорилт 62 хувьтай, хөтөлбөрийн биелэлт 74 хувьтай, зарим стандарт, хуулийн зүйл заалтыг шинэчлэх шаардлагатай байна.

1.1.1 Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний хэрэгжилт 62 хувьтай, 3 арга хэмжээг үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгаагүй, хэрэгжүүлээгүй байна.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журам, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа салбарын харилцааг зохицуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ыг баталж өгсөн байна. Уг бодлогын баримт бичиг 8 зүйлээс бүрдэх бөгөөд 4 дүгээр зүйлд хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрлэлийн талаар авч хэрэгжүүлэх 18 арга хэмжээг тусгасан байна.

Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт: Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, "Монгол мал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн, газар тариалангийн үйлдвэрлэл, нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлэх зэрэг 10 арга хэмжээг тусгасан нь бодлогын баримт бичигтэй уялдаж байна. Харин 4.1.3¹, 4.1.13², 4.1.15³ дахь арга хэмжээг хэрэгжүүлэхээр огт тусгаагүй, орхигдуулсан байна.

1.1.2 Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үндэсний стандартын шинэчлэлийг хийхдээ нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай байна.

Хүнсний сүлжээнд шууд ба шууд бус хэлбэрээр оролцдог, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллага гэдэгт малын тэжээл, амьтны хоол үйлдвэрлэгч, байгалийн ургамал, ойн дагалт нөөцийг бэлтгэгч, фермер, орц найрлагын бүрэлдэхүүн хэсгийг үйлдвэрлэгч, хүнсний боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч, жижиглэн худалдаачид, хоол үйлдвэрлэл, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч, ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ, тээвэр, хадгалалт, түгээлтийн үйлчилгээ эрхлэгч, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, сав баглаа боодол, хүнстэй харьцах гадаргууг үйлдвэрлэгч, нийлүүлэгч зэрэг хамаардаг байна.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хүнсний салбартай холбоотой 201 стандарт мөрдөгдөж байна. Эх сурвалж: www.estandart.gov.mn

Дараах стандартуудыг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх шаардлагатай байна. Үүнд: хэвийн боов MNS 0461-1981, жигнэмэл гурилан бүтээгдэхүүн 2488-1999

Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үндэсний стандарт өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна. Гэвч стандартын шинэчлэлийг хийхдээ өмнөх нөхцөл байдлаа харгалзан үзэх шаардлагатай байна.

¹ стратегийн хүнсний улирлын нөөцийг эрэлт, нийлүүлэлт, хэрэглээний онцлогтой уялдуулан хувийн хэвшлийн оролцоотойгоор бүрдүүлэх

² шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, судалгааны дүнд суурилан зохицуулах үйлчилгээтэй хүнсийг үйлдвэрлэлд турших, нэвтрүүлэх

³ нийтээр нь үйлчлэх (сургууль, цэцэрлэг, эмнэлэг, цэргийн анги, хорих газар болон тэдгээртэй адилтгах бусад) хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, шим тэжээлийн агууламжийг дээшлүүлэх, нэгдсэн жор, технологийг боловсруулах, мөрдүүлэх, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх, дотоод хяналтыг сайжруулах



Тухайлбал: Хүнсний тухай хуулийн 10.1.2⁴ дэх заалтын дагуу Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ Ерөнхий шаардлага MNS5021-1:2019 стандартыг 2019 оны 10 дугаар сарын 10-аас мөрдөж эхэлсэн. Уг стандартад хүнсний дэлгүүрийн хүчин чадал талбайн хэмжээг 40-100 м² байхаар тусгаж өгсөн нь өмнө баригдсан байсан дэлгүүрүүдийн тухайд мөрдөх боломжгүй болсон байна. Өөрөөр хэлбэл тухайн барилга байгууламжийг өргөтгөх эсвэл дахин шинээр барьж байгуулах хэрэгцээ шаардлага үүссэн байна.

1.1.3 Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ 69 хувьтай хэрэгжсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор "Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд аймгийн тухайд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргасан, биелэлтийг 88 хувьтай дүгнэж ирүүлсэн, аудитаар давтан тооцоолоход 74 хувьтай байна.

Холбогдох газруудаас хүнсний салбарт хэрэгжиж байгаа дараах үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн биелэлтийг тооцон гаргаж ирүүлсэн бөгөөд дунджаар 69 хувьтай байна. Үүнд:

- "Монгол Мал-ГАА" дэд хөтөлбөр аймгийн ИТХ-аас батлан 2017-2021 онд хэрэгжүүлсэн бөгөөд биелэлтийг 86.47 хувьтай дүгнэж ирүүлсэн, аудитаар дахин тооцоход 85 хувьтай
- "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-ыг Говь-Алтай аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн 2012-2020 онд хэрэгжүүлсэн бөгөөд биелэлт 96.4 хувьтай, аудитаар дахин тооцоход 84.8 хувьтай
- "Ус" дэд хөтөлбөрийн 2020 оны биелэлтийг 100 хувьтай гаргаж ирүүлсэн, аудитаар дахин тооцоход 94.1 хувьтай
- Малын эмийн үлдэгдлийн хянах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 65.0 хувьтай, аудитаар давтан тооцоход 58 хувьтай
- Төмс дэд хөтөлбөрийн биелэлт 95.2 хувьтай, аудитаар давтан тооцоход 81.0 хувьтай
- Хүлэмж дэд хөтөлбөрийн биелэлт 87.6 хувьтай, аудитаар давтан тооцоход 82.0 хувьтай
- Жимс жимсгэнэ үндэсний хөтөлбөрийн биелэлт 100 хувьтай, аудитаар тооцоход бодитой хэрэгжсэн байна.
- Сав баглаа боодол үндэсний хөтөлбөрийн биелэлтийг тооцож гаргаагүй байна
- Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөрийн биелэлтийг 94 хувьтай, аудитаар давтан тооцоход 77 хувьтай тус тус хэрэгжсэн байна.

Аймгийн ЗДТГ-аас төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хянаж 10 хөтөлбөрийн биелэлтийг 71.4 хувьтай дүгнэж, баталгаажуулан холбогдох яаманд хугацаанд нь хүргүүлсэн байна.

⁴ стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх

1.1.4 Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5¹.2, 5³.3 дахь заалт нь төрийн хяналт шалгалтын үр нөлөөг бууруулж байна.

“Хүнсний тухай хуулийн 3.1.2-т “хүнсний аюулгүй байдал” гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байх тухай тодорхойлсон.

Аудитаар “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн хэрэгжилт бодит байдал дээр хэрхэн хэрэгжиж байгаатай танилцаж, ажиглалт хийхэд дараах хуулийн заалтууд хэрэгжихгүй байна. Үүнд:

- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хуулийн 10.1.3⁵, 10.1.6⁶, 10.1.7⁷, 12.8⁸ дэх заалтад заасан үүргээ хэрэгжүүлэхгүй, 10.3.1⁹ дэх заалтад заасан хориглосон үйл ажиллагаа явуулж байна.

Тухайлбал: Ажиглалтаар 19 ААНБ-ын 11 ААНБ нь ажиллагсдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан дэвтэргүй, 19 ААНБ бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөөгүй, 7 ААНБ хаяг шошгын зөрчилтэй байсан. Үүний дагуу зөрчлийн тухай хуулийн 6.15 дахь заалт “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль зөрчих”-ын дагуу арга хэмжээ тооцох боломжгүй байна. Учир нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5¹.2¹⁰ 5³.3¹¹ дэх заалтын дагуу шалгагдагч этгээдэд урьдчилан мэдэгдэхэд тухайн үедээ зөрчлөө нуун дарагдуулсан байдаг тул арга хэмжээ тооцох боломжгүй байдаг байна. Иймд уг хуулийн заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

1.2. Хүнсний аюулгүй байдлын бодлого, арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хянаж байгаа оролцогч талуудын чиг үүрэг тодорхой бус, ажлын уялдаа холбоо сул байна.

1.2.1 Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаар төрөөс нэгдсэн бодлогоор зохицуулаагүй байна.

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр төрөөс хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр байна. Гэтэл аймгийн ИТХ, Засаг даргаас чиглэсэн ямар нэгэн бодлого үйл ажиллагаа явуулаагүй байна. Энэ нь Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1¹², 17.1.1¹³, 17.1.2¹⁴ дах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

⁵ энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөх

⁶ хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох болон дотоод хяналт, шалгалтын бүртгэл, тэмдэглэл, тайлан тооцоо, лабораторийн шинжилгээний хариу зэрэг мэдээлэл болон баримт бичгийг хадгалах

⁷ хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах

⁸ Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний багцалсан болон жижиглэн савласан сав, баглаа боодол дээрх шошгыг тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон худалдаа эрхлэгч хариуцна

⁹ хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх; 10.3.2.энэ хуулийн 10.1.7, 10.1.8, 10.2-т заасан эрүүл мэндийн шаардлага хангаагүй ажилтныг ажлын байранд нэвтрүүлэх

¹⁰ Хяналт шалгалтын байгууллага төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухайгаа шалгуулах этгээдэд таваас доошгүй хоногийн өмнө шуудангаар, утсаар, эсхүл биечлэн мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд шалгалт хийх байгууллагын нэр, шалгалт эхлэх ба дуусах хугацааг заана

¹¹ Гүйцэтгэлийн шалгалт хийхдээ шалгуулагч этгээдэд ажлын хоёроос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

¹² тухайн нутаг дэвсгэрт хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;

¹³ тухайн нутаг дэвсгэрт хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар явуулах үйл ажиллагааны бодлого, төлөвлөгөө болон түүнд зарцуулах хөрөнгийн төсвийг хэлэлцэж батлах

¹⁴ тухайн нутаг дэвсгэрт хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөх



холбоогүй зэрэг шалтгааны улмаас хүний эрүүл мэндэд хохирол учруулсан зөрчлийг илрүүлэх, бүртгэх, арилгах үйл ажиллагаа бүрэн хангагдахгүй байна.

Орон нутгийн МХГ-аас хяналт шалгалтын төлөвлөгөөг олон нийтэд мэдээлсэн эсэхийг тодруулахад манайх www.inspection.gov.mn, www.shilenhyanal.gov.mn цахим хуудсаар мэдээлдэг гэсэн тайлбар өгсөн. Уг цахим хуудаст бүртгэлтэй иргэн, ААН уг системд нэвтрэн орж харах боломжтой, иргэд олон нийт харах боломжгүй байдаг.

Аймгийн дэлгэрэнгүй хяналт шалгалтын төлөвлөгөө байхгүйгээс хаана ямар объектод хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн, түүнийг гүйцэтгэсэн эсэх тодорхойгүй байна.

МХГ-ын хяналт шалгалтын талаар:


МХЕГ-ын даргын 2019 оны А/67 “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандарт батлах тухай” тушаалаар шалгалт, урьдчилсан сэргийлэх хяналт, тандалт судалгаа, хяналт шинжилгээ, зөвлөн туслах үйлчилгээ гэсэн 5 төрлийн шалгалтын хэлбэрийг баталж өгсөн байна.

Аудитаар ирүүлсэн хяналт шалгалтын баримтыг нэгтгэн, байгууллагын мэдээтэй тулган баталгаажуулахад 2018 онд 2, 2019 онд 5 нийт 7 ААНБ-д хяналт шалгалт хийсэн баримт материалыг бүрдэл дутуу, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах үйлчилгээ, тандалт судалгаа, хяналт шинжилгээний шалгалтуудын материалыг ирүүлээгүй байсан.

Аудитын тайлангийн төсөл танилцуулагдсаны дараа буюу 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр дээрх дутуу баримт материалыг ирүүлсэн. Иймээс цаашид баримт материалаа цаг хугацаанд нь бүрэн гүйцэд ирүүлдэг байх шаардлагатай байна.

Аудитаар ирүүлсэн баримт материалд анализ дүгнэлт хийхэд нийт шалгалтад хамрагдсан объектын хуулийн мөрдөлтийг чиглэл тус бүрээр дүгнэхэд:

Дүрслэл №2: Хуулийн шаардлага хангаагүй салбарын зөрчлийн нэгтгэл /хяналтын хуудсаар 2018-2020 он/



- Хяналт шалгалтаар 2018 онд нийтээр үйлчлэх хоол үйлдвэрлэл 40 хувь, ундны усны чанар аюулгүй байдал 39 хувь, цэцэрлэгийн эрүүл ахуй халдвар хамгаалал 44 хувь, дотуур байрны эрүүл ахуй халдвар хамгаалал 39 хувь, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эрүүл ахуй 64 хувь нь хуулийн шаардлага хангаагүй гарсан байна.
- Хяналт шалгалтаар 2019 онд хоол үйлдвэрлэл үйлчилгээ 39 хувь, нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл 39 хувь, ундны усны чанар аюулгүй байдал, 42 хувь, мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл 44 хувь, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 42 хувь нь хуулийн шаардлага хангаагүй байна.
- Хяналт шалгалтаар 2020 онд нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл 40 хувь, мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл 38 хувь, гурилан бүтээгдэхүүний

үйлдвэрлэл 39 хувь нь хуулийн шаардлага хангаагүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзнэ үү/

Эндээс дүгнэхэд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар хоол үйлдвэрлэл үйлчилгээ, нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, ундны усны чанар, мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлүүд бусад хүнсний салбартай харьцуулахад хуулийн шаардлага хангаагүй хувь өндөр байна. Энэ нь хүнсний гол нэр төрөл болох мах, гурил будаа чанар стандарт аюулгүй байдал талаасаа бүрэн хангагдахгүй байгааг харуулж байна.

Дүрслэл №3: Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар илэрсэн зөрчил /тоогоор/



Эх сурвалж: МХГ-ын статистик мэдээ

Дээрх дүрслэлээс харахад: 2019 онд илэрсэн зөрчил өссөн, 2020 онд буурсан үзүүлэлттэй байна. Энэ цар тахал гарснаар 2018 онд 134 объект, 2019 онд 135 объект, 2020 онд 95 объект болж буурсантай холбоотой байна.

- Хүнсний чанар, стандартын хяналтаар 2018 онд 658 зөрчил буюу 33.2 хувь, 2019 онд 839 зөрчил буюу 31.3 хувь, 2020 онд 600 зөрчил буюу 29.1 хувийг эзэлж, 2020 онд зөрчил буурсан байна.
- Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтаар 2018 онд 539 зөрчил буюу 32.9 хувь, 2019 онд 716 зөрчил буюу 26.6 хувь, 2020 онд 294 зөрчил буюу 19.1 хувийг эзэлж, 2020 онд зөрчил буурсан байна.
- Мал эмнэлгийн хяналтаар 2018 онд 195 зөрчил буюу 33.7 хувь, 2019 онд 300 зөрчил буюу 26.3 хувь, 2020 онд 326 зөрчил буюу 27.9 хувийг эзэлж, жил ирэх тусам зөрчил өссөн байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах хугацаа өгч, зарим газар гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийсэн байна. Гүйцэтгэлийн шалгалтыг ямар байгууллагад орж байгаа нь тодорхойгүй байна. Гүйцэтгэлийн шалгалтаар албан шаардлага хүргүүлэн зөрчлийн хувь буурсан байгаа боловч, зөрчил бүрэн арилаагүй, үр нөлөөг тооцоогүй давтан гарч байгаад тавих хяналт сул байна.

✚ **Хураасан устгасан бараа бүтээгдэхүүний талаар:**

Есөнбулаг сумын ЗДТГ, МХГ-аас ирүүлсэн хураасан устгасан бараа бүтээгдэхүүний тулгалт хийхэд: МХЕГ-ын удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 44 объектоос хэрэглээний баталгаат хугацаа дууссан 9,466.9 мянган төгрөгийн 6,271 ширхэг бүтээгдэхүүн хураан авснаас 12 объектод 3,800.0 мянган төгрөгийн зөрчлийн хэрэг үүсгэн торгууль ногдуулсан ба 10 ААНБ хүсэлтээр ирүүлэн, үлдсэн 22 объектод ямар арга хэмжээ авсан нь тодорхойгүй баримтаа ирүүлээгүй байна.

Мөн хэрэглээний баталгаат хугацаа дууссан ААНБ-ын бүтээгдэхүүнийг хураан авахдаа МХЕГ-ын даргын 2019 оны А/67 "Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий

шаардлага стандарт батлах тухай” тушаалын дагуу бараа хураах, устгах актыг үйлдсэн байна.

➤ **Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн талаар**

Аймгийн МХГ болон ЗДТГ-ын дэргэдэх 70481111 санал, гомдол хүлээн авах дугаарт хүнстэй холбоотой гомдол 2018 онд 2, 2019 онд 3, 2020 онд 7 нийт 15 бүртгэгдсэн байна. Гомдол саналын дийлэнх нь хэрэглээний баталгаат хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүн, мах, сүү, ногооны үнийн өсөлт болон ил задгай худалдаатай холбоотой, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлт болон ил задгай худалдаалах үйл ажиллагаа байна.

Хүснэгт №1: Иргэд, ААНБ-аас ирсэн гомдол мэдээлэл:

Д/д	Утга	2018		2019		2020	
		МХГ	ЗДТГ	МХГ	ЗДТГ	МХГ	ЗДТГ
1	Мах, сүү, ногооны үнийн өсөлттэй холбоотой						2
2	Ил задгай худалдаалах үйл ажиллагаатай холбоотой						4
3	Хэрэглээний баталгаат хугацаатай	1			2		
4	Муу махаар хоол хийсэн			1			
5	Хордлого авсан	1				1	
Нийт дүн		2	0	1	2	2	6

- МХГ-т ирүүлсэн 5 өргөдөл гомдлоос 1 иргэн өргөдөл гомдлоо татаж, 4 өргөдөл гомдлын дагуу асуудлыг шийдвэрлэсэн байна. Хүнснээс хордлого авсан өргөдлийн мөрөөр улсын байцаагч торгуулийн арга хэмжээ авсан байна.
- Аймгийн санал, гомдол хүлээн авах 70481111 утсаар 2019-2020 онд ирүүлсэн 8 өргөдөл гомдлоос 4-ийг шийдвэрлэсэн ба 4 зөрчил нь мал махны ил задгай худалдаатай холбоотой гомдол байна. Тус үйл ажиллагаа одоо ч бодит байдал дээр арилаагүй, эрүүл ахуйн шаардлага хангахгүй орчинд ил задгай худалдаалсаар байна.

➤ **Хяналт шалгалтын ОУ-ын жишиг, сайн туршлага**

Аудитын хүрээнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа ААН-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Швейцар улсын туршлагыг судлахад нэг объектод жилд 5 төрлийн шалгалт холбогдох эрх бүхий байгууллагаас ирдэг байна. Үүнд:


1. Зөвлөх шалгалт (гэнэтийн болон төлөвлөгөөт)-Ариун цэвэр, эрүүл ахуй, ажлын байрны аюулгүй байдал зэргийг хянадаг.
2. Чанарын шалгалт-3 сар тутам ирдэг, хэрэглэж буй бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг голчлон шалгаж, хоол үйлдвэрлэлийн процессыг ашиглаж дүгнэлт өгнө.
3. Чанарын ерөнхий шалгалт-Жилд нэг удаа ирдэг, шалгалтын хугацаа бүтэн өдөр үргэлжилнэ, үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авдаг.
4. Сертификат баталгаажуулах шалгалт-Шинэ бүтээгдэхүүн, шинэ хоолны цэс гаргах үед ирдэг.
5. Гэнэтийн шалгалт-дунджаар 2 сар тутам ирдэг.

Швейцар улс нь хүнсний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бүх ААНБ-даа жилд заавал 1 удаа чанарын ерөнхий хяналт, мөн гэнэтийн, чанарын, зөвлөх шалгалтуудыг 2-3 сарын зайтай хийдэг байна.

Аймгийн хэмжээнд МХГ-аас ирүүлсэн судалгаагаар хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа 559 объект байна. Хүнсний чанар, стандартад тавих төлөвлөгөөт хяналтыг 2018 онд 47, 2019 онд 54, 2020 онд 36, зөвлөн

туслах үйлчилгээний хяналтыг 2018 онд 19, 2019 онд 21, 2020 онд 10 гэж баталсан байна. Энэ нь нийт объектын 10-11 хувийг эзэлж байна. Нөгөө талаас бүгдийг хамруулан шалгахад ойролцоогоор 8-12 жил шаардлагатай байна. Иймд объектуудыг жилд 1 удаа шалгалтад бүрэн хамруулж, хяналтыг үр нөлөөтэй болгохын тулд мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлж, мэдлэг арга зүйгээр хангаж, нэгдсэн 1 арга барилтай болгон, шалгалтын шинэлэг хэлбэрийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

9. Хүнсний аюулгүй байдлын хянаж буй өнөөгийн тогтолцоо үр дүнтэй байна уу?
102 responses



Дүрслэл №4: Санал асуулгын үр дүн
/хяналтын тогтолцоо/

Санал асуулгын үр дүнгээс харахад хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр дүнтэй байна уу гэсэн асуултад 54.9 хувь нь үр дүнгүй, 39.2 хувь нь мэдэхгүй, 5.9 хувь нь үр

дүнтэй гэж хариулжээ. Үүнээс харахад иргэд олон нийтийн дунд энэ талаарх мэдээлэл хомс, хяналт үр дүнгүй гэж дүгнэжээ.


➤ **Хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад хийсэн аудитын ажиглалтын талаар:**

Аудитаар 19 хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд ажиглалт хийхэд жижиглэн савласан бүтээгдэхүүн дээр ХБАБХТХ-ийн 12.4-д заасан мэдээлэл болон шошго, савласан огноог бичээгүй, үйлдвэрлэсэн огноог тэмдэглээгүй, орчин нөхцөл эрүүл ахуйн шаардлага хангахгүй, ажиллагсад эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан дэвтэргүй, тогтмол хамрагддаггүй, хөргөгч, хөлдөөгчийн температурын заалтыг хянаж бүртгэл хөтөлдөггүй, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл өмсөж хэвшээгүй, хугацаа нь дууссан бүтээгдэхүүн худалдан борлуулж байлаа.

Зураг 1: Жижиглэн савласан бүтээгдэхүүнд хаяг шошгын мэдээлэлгүй



Зураг 2: Хугацаа дууссан бүтээгдэхүүн худалдан борлуулсан зөрчил



Зураг 3: Үйлдвэрлэсэн огноог тэмдэглээгүй зөрчил



Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-272 "Норматив тогтоох тухай" тушаалаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, нийслэл, суманд 1000 хүн ам тутамд 4 хүртэл байхаар тогтоосон. Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс ирүүлсэн судалгаанд үндэслэн тооцоход Есөнбулаг сумд согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо норматив хэмжээнээс 27-оор илүү, Чандмань сумд 2-оор илүү байна.

1.2.4 Хоол хүнсээр дамжих өвчлөл 2018-2020 онд 27 бүртгэгдсэн бөгөөд хариу арга хэмжээ аваагүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоол “Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.12-т заасан бодлогыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн бодлогоор зохицуулахаар байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Журам заавар шинэчлэн батлах тухай” А/328 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар “хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ авах журам”-ын 3.6 дахь заалтын дагуу аймгийн ЭМГ нь хоол хүнсээр дамжих өвчлөлийн мэдээг сар бүрийн 25-ны өдрийн дотор маягт 1, маягт 2-ын дагуу гарган хугацаанд нь хүргүүлсэн байна.

Аймгийн тухайд 2018-2020 онд хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт бүртгэгдээгүй, өвчлөл 27 бүртгэгдсэн байна. Хоол хүнсээр дамжих өвчлөл бүртгэгдсэн үед мэргэжлийн байгууллагад мэдэгдэж арга хэмжээ авсан зүйл байсангүй.

Дүрслэл №5: Санал асуулгын үр дүн /хоолны хордлого/

2. Та болон таны эргэн тойрны хүмүүс хугацаа нь дууссан болон кадгалалтын горим алдагдсан хүнсний бүтээгдэхүүн худалдан авсны улмаас хоолны хордлогод орж байсан уу?
100 responses



Иргэдээс цахимаар санал асуулга авахад судалгаанд оролцсон нийт 100 хүний 30 хүн буюу 30 хувь нь ямар нэгэн хэмжээгээр хоолны хордлогод орж байсан гэж хариулжээ. Эндээс харахад иргэд олон нийт хоолны хордлого авсан бол холбогдох мэргэжлийн байгууллагад тэр бүр мэдэгддэггүйг өнгөрөөдөг, энэ талаарх мэдлэг сул байгааг харуулж байна.

1.3 Аймгийн хэмжээнд чанар стандартад нийцсэн, эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр жигд, тогтвортой хүртээмжтэй баталгаатай хангагдахгүй байна.

1.3.1 Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх талаар ямар нэгэн бодлого үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй байна.

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтад аймгийн Засаг дарга стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг тусгасан байна. Аймгийн тухайд 2018-2020 онд стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх талаар ямар нэгэн бодлого үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй байна.

Зураг 4: Албан тоот /ЗДТГ/



1.3.2 Малын гаралтай түүхий эдийг бүрэн, үнэн зөв шинжлэх лабораторийн хүчин чадал хүрэлцээ муу байна.

Аймгийн хэмжээнд МХГ-ын, Мал эмнэлгийн, “Шинэ-Алтай” захын лабораториуд үйл ажиллагаагаа явуулж байна.

МХГ-ын лаборатори: Тус газрын лаборатори нь 1996 оноос хойш үйл ажиллагаа явуулж байна. Анх 2005 оноос эхлэн үндэсний түвшинд итгэмжлэгдсэн бөгөөд 2009, 2014, 2017 онд давтан итгэмжлэл, 2013, 2017 онд итгэмжлэлийн хүрээгээ өргөтгөх шалгалтаар

хугацаагаа сунгуулан үйл ажиллагаа явуулах эрхээ баталгаажуулсан байна. Нян судлал 29 төрлийн бүтээгдэхүүнд 134 үзүүлэлтээр, химийн хор судлал 279 үзүүлэлтээр, таримал ургамлын үр, хорио цээрийн лаборатори 12 бүтээгдэхүүнд 48 үзүүлэлтээр итгэмжлэлийн хүрээнд дээжээс шинжилж байна. Хими шинжээч-2, нян судлаач шинжээч-1, хорио цээрийн шинжээч-1, лаборант-2 гэсэн 6 орон тоотой байна. Лабораторийн хүчин чадал хангалттай, хүний нөөц, тоног төхөөрөмж, урвалж бодис хүрэлцээтэй байна.

Аудитын явцад улсын байцаагчтай "Шинэ-Алтай" захын хүнс, жимс жимсгэнийн худалдаа эрхэлдэг ААНБ-ын 3 дээжээс "greentest" багажийн тусламжтайгаар нитратын хэмжээг үзэхэд зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр гарсан. Иймд шинжилгээг баталгаажуулах зорилгоор МХГ-ын лабораторийн шинжилгээнд хамруулахад авч хөнөөлт шавж, нитратын хэмжээг шинжлүүлэхэд эерэг сорьц гараагүй байна.

Лабораторийн шинжилгээний төлбөрийг давтан тооцоолоход 2018-2020 онд 1,755.3 мянган төгрөгийн шинжилгээний төлбөрийг дутуу тооцож авсан байна. Энэ нь сангийн сайдын 2017 оны 253 дугаар тушаал "Хэмжилт, шинжилгээ, халдваргүйжүүлэлтийн үнийг батлах тухай"-ыг зөрчсөн байна.

Мал эмнэлгийн лаборатори: Тус газрын лаборатори нь 1923 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд анх 2006 онд итгэмжлэлээ авч, 2008, 2010, 2014, 2021 онуудад сунгуулсан байна. 5 төрлийн сорилын шинжилгээг 8 бүтээгдэхүүнд 77 үзүүлэлтээр шинжилгээг хийж байна. Лабораторийн эрхлэгч, ийлдэс судлаач -1, ариун цэврийн шинжээч-1, нян судлаач-1, Шимэгч судлалын шинжээч -1, нийт 4 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Аудитын явцад "Шинэ-Алтай" захын 4 газрын махны эрүүл ахуй шинэлэг байдлыг тодорхойлох шинжилгээг авч шинжлүүлэхэд ямар нэгэн зөрчил илрээгүй. Шинжилгээний төлбөрийн давтан тооцоолоход 2018-2020 онд 18.0 мянган төгрөгийн шинжилгээний төлбөрийг дутуу тооцож авсан байна.

"Шинэ-Алтай" захын лаборатори: "Шинэ-Алтай" захын мах, сүү цагаан идээний лаборатори нь 2009 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд зөвшөөрөлгүй буюу итгэмжлэлийн гэрчилгээ аваагүй ч иргэдээс махны шинэлэг байдлыг тодруулахаар бод малын махнаас 1 дээжийг 10.0 мянган төгрөг, бог малаас 1.5 мянган төгрөг, сүү цагаан идээний найрлагыг 3.0 мянган төгрөгөөр тооцож авдаг, мөн ил задгай махны худалдаа эрхлэгч нараас зогсоолын төлбөр 10.0 мянган төгрөгийг авдаг зэрэг хууль бус үйл ажиллагаа явагдаж байгаа. Тус лаборатори нь 2018-2020 онд нийт 34,924.3 мянган төгрөгийн шинжилгээний орлогыг олсон байна. Итгэмжлэлгүйгээр шаардлага хангахгүй орчинд дээж авч шинжлэн, эрүүл ахуйн шаардлага хангахгүй орчинд ил задгай худалдаалагчдыг дэмжин, түүнээсээ ашиг хүртэж байгаа энэ үйл ажиллагаа нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Энэ асуудалд МХГ, Мал эмнэлгийн газраас хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1¹⁵, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.7¹⁶ дах заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын 2020 оны А-303 тоот хавсралт "мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам" 6 дугаар зүйлийн 6.1.1¹⁷, 6.1.2¹⁸ дахь заалтыг зөрчсөн.


¹⁵ Мал эмнэлгийн төрийн хяналтыг улсын хэмжээнд мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллага, тэдгээрийн улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагч хэрэгжүүлнэ

¹⁶ Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналттай холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулна

¹⁷ Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллагын дарга харьяа нутаг дэвсгэрт сүлжээ лабораторийн журмын хэрэгжилтийг хангуулах талаар мал эмнэлгийн лабораторийн эрхлэгчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнг тооцох

¹⁸ Харьга мал эмнэлгийн лабораторийн бүртгэл хөтөлж, тэдгээрийг мэргэжил арга зүйн удирдлага, мэдээллээр хангах, зөвлөмж өгөх

Зураг №5,6,7: Шинэ-Алтай захын лабораторийн нөхцөл байдал



Доорх хүснэгтээс харахад сүүлийн 3 жил Мал эмнэлгийн газрын болон "Шинэ-Алтай" захын лабораторийн шинжилгээнээс эерэг сорьц илрээгүй байгаа нь чанартай шим тэжээллэг малын гаралтай түүхий эдийг хүнсэндээ хэрэглэж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.


Иймд ажилтны ур чадвар, тоног төхөөрөмж, урвалж бодис, итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлж, нарийн шинжилгээнүүдийг хийх шаардлагатай байгааг харуулж байна.

Хүснэгт №2: Лабораториудын шинжилгээний дээж, дүнгийн мэдээлэл

Лабораторийн нэр	Огноо	Ирсэн ААН-ын тоо	Дээжийн тоо	Нийт үзүүлэлтийн тоо	Эерэг сорьц		Сөрөг сорьц	
					Тоо	Үзүүлэлт	Тоо	Үзүүлэлт
"Шинэ-Алтай" ХХК	2018	1282	1282	2,564.00	-	-	2,564.00	2,564.00
	2019	798	798	1,596.00	-	-	1,596.00	1,596.00
	2020	1022	1022	2,044.00	-	-	2,044.00	2,044.00
	2021	481	481	962.00	-	-	962.00	962.00
	дүн	3583	3583	7,166.00	-	-	7,166.00	7,166.00
Мал эмнэлгийн газар	2018	12	12	383.00	-	-	2.00	383.00
	2019	7	7	473.00	-	-	2.00	473.00
	2020	9	9	231.00	-	-	2.00	231.00
	2021	4	4	40.00	-	-	2.00	40.00
	дүн	32	32	1,127.00	-	-	8.00	1,127.00
МХГ-н лаборатори	2018	1523	1523	6,242.00	100.00	138.00	1,423.00	6,104.00
	2019	2203	2203	5,794.00	67.00	93.00	2,136.00	5,701.00
	2020	1955	1955	4,387.00	142.00	193.00	1,813.00	4,194.00
	2021	429	429	1,488.00	40.00	56.00	389.00	1,392.00
	дүн	6110	6110	17,911.00	349.00	480.00	5,761.00	17,391.00

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/255 дугаар захирамжийн дагуу Есөнбулаг суманд үйл ажиллагаа явуулж байгаа хоол үйлдвэрлэлийн газруудыг 14 хоног зогсоосонтой холбоотой аймгийн МХГ-аас "Шинэ-Алтай" захын худалдаа үйлчилгээний төвийн махны худалдаа эрхлэгч 22 иргэнээс 8 төрлийн /гар, хормогч, лангуу, махны дэвсгэр, жин, өлгүүр, машин хөлдөөгч/ 100 ширхэг эрүүл ахуйн арчдас авч МХГ-ын лабораториор шинжлүүлэхэд 94 хувьд нь E.Coli илэрсэн нь эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй тул үйл ажиллагааг зогсоож их цэвэрлэгээг хийлгэж, эрүүл ахуйн шаардлага хангуулж ажиллахыг "Шинэ-Алтай" захын удирдлагад мэдэгдсэн байна. Уг мэдэгдлийн дагуу ямар арга хэмжээ авч ажилласан нь тодорхой бус байна.

Зураг №8,9: “Шинэ-Алтай” зах дээр махны ил задгай худалдаа /2021 оны 10 сарын 12 өдөр/



Аймгийн “Шинэ-Алтай” захын гадна махыг бүтэн гулуузаар нь авч ирээд ил задгай бөөндөж зардаг жишиг тогтсон байна. Тиймээс шаардлага хангахгүй орчин нөхцөлд махыг худалдан борлуулж буй үйл ажиллагааг зогсоохгүй бол хүнсний аюулгүй байдал алдагдаж, иргэд олон нийт эрүүл мэндээр хохирох эрсдэлтэй байна.

1.3.3 Аймгийн хэмжээнд дотоодын үйлдвэрлэл, хүнсний хангамж, хүртээмжийг тооцож гаргаагүй байна.


Аймгийн Статистикийн хэлтсээс хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, хангамжийн тоо мэдээлэл гаргаагүй байна. ХХААГ нь 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр 2018-2020 оны дотоодын үйлдвэрлэл, хүнсний хангамжийг мэдээг нөхөж гаргаж ирүүлсэн боловч уг тоо мэдээлэл үнэн зөв эсэх нь эргэлзээтэй байна. Учир нь Статистикийн хэлтсээс ирүүлсэн хүн амын тооноос жишсэн хүн амыг тоог гарган тулган баталгаажуулахад зөрүүтэй байсан.

➤ Хүнсний хангамж:

Иймд аргачлалын дагуу тооцож үзэхэд 2018-2020 онд махны хэрэгцээгээ дотооддоо бүрэн хангаж байгаа үзүүлэлттэй боловч энэ нь ястай махаар тооцсон үзүүлэлт байна. Учир нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын “хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай” 4 дүгээр хавсралтад жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ махыг хоногт 120 гр-аар тогтоосон байна. Гэтэл холбогдох мэргэжлийн байгууллага буюу ХХААЯ хангамжийг тооцохдоо ястай махаар тооцож байна. /хавсралт №2/

Зураг №10: Албан тоот
/Статистикийн хэлтэс/

Дүрслэл №6: Хүнсний эрхий бичгийн үйлчилгээнд хамрагдагч өрх



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ыг шинэчлэн баталсан байна. Энэ оны 10 сарын байдлаар 617 өрхийн 3094 хүнд хүнсний эрхийн бичгийг олгож байна. Аймгийн хэмжээнд хамгийн олон буюу Есөнбулаг сумд 419 өрх, хамгийн бага

буюу Тонхил сумд 5 өрх байгаа бол Алтай сум, Цогт сумын Баянтоорой тосгонд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрх байхгүй ажээ.

Аймгийн МХГ-аас 2020-2021 оныг хамруулан Нийгмийн халамжийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж дараах дүгнэлтийг өгсөн байна. Үүнд:

- Хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдсан зарим өрхүүдийн хувийн хэргийн бүрдэл хангалтгүй, баяжилтыг тухай бүр хийдэггүй. Үүнд хяналт шинжилгээ хариуцсан нэгж хяналт тавиагүй.
- Хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй, ил тод харагдахаар байршуулаагүй.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан хүнсний эрхийн бичиг авах эхний 6 сараас хойш хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас санал болгосон арга хэмжээнд 2-оос доошгүй удаа хамрагдсан, ажил хайгчаар бүртгүүлж 2-оос доошгүй ажил олгогчтой уулзаж ажил идэвхтэй хайж буй иргэдийн мэдээллийг шинэчилж, хяналт тавьдаггүй.

1.3.4 Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний олон улсын жишиг стандартыг хүнсний сүлжээний бүх үе шатанд нэвтрүүлээгүй байна.

Ургамал хамгааллын тухай хуулийн 13.2.2-т ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг тээвэрлэх, борлуулахдаа тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ авахаар заасан боловч бодит байдал дээр энэ хуулийн заалт бүрэн хэрэгжихгүй байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.4.2 “нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, худалдах, төхөөрөх зорилгоор мал, амьтныг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гаргахдаа мал эмнэлгийн улсын байцаагчаас мал эмнэлгийн гэрчилгээ авч бүртгүүлэх тухай” хуульчлан заажээ. “Мал эмнэлэг гэрчилгээ”-г цахимжуулан, хянах системийг нэвтрүүлсэн хэдий ч энэ талаарх иргэдийн мэдлэг мэдээлэл хомс байна.


Аймгийн ХХААГ-аас ирүүлсэн хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгаанд үндэслэн тооцоход 77 нэр төрлийн бүтээгдэхүүн Тохирлын үнэлгээнд хамрагдаагүй, хамрагдсан бүтээгдэхүүний тохирлын үнэлгээний хүчинтэй хугацаа дууссан байна.

Дүрслэл № 7: Санал асуулгын үр дүн /хадгалалт, хамгаалалт/

1. Таны үйлчлүүлдэг дэлгүүр, худалдааны төв хугацаа нь дууссан хүнсний бүтээгдэхүүн борлуулдаг уу?
102 persons



3. Таны үйлчлүүлдэг дэлгүүр, худалдааны төв тусгай хадгалалтын горим шаардах хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын хөргүүрт хадгалалт, борлуулдаг уу?
102 persons



Санал асуулгын үр дүнгээс харахад дэлгүүр худалдааны төв нь хугацаа дууссан бүтээгдэхүүн борлуулдаг уу гэсэн асуултад 38.2 хувь нь тийм гэж хариулсан, 49 хувь нь заримдаа гэж хариулжээ. Мөн бүтээгдэхүүнийг зориулалтын хөргүүрт хадгалдаг уу гэсэн асуултад 76 хувь нь тийм гэж хариулжээ.

1.3.5 Хүнсний сүлжээний бүх үе шатны нэгдсэн бүртгэл хангалтгүй, хяналт, мэдээллийн тогтолцоо үр дүнгүй байна.

Аймагт хоол, үйлдвэрлэл үйлчилгээ, хүнсний үйлдвэр үйлчилгээ, Хүнсний худалдаа гэсэн 3 чиглэлээр үйл ажиллагаа байгаа иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг МХГ, ХХААГ, аймгийн ЗДТГ-аас гаргуулан авахад дараах байдалтай байна.

Хүснэгт №3: Хүнсний салбарын ААНБ-ын тоо, мэдээллийг харьцуулсан судалгаа

Д/д	төрөл	АЗДТГ	МХГ	ХХААГ	Зөрүү
1	Хоол, үйлдвэрлэл үйлчилгээ	Нэгдсэн	117	43	74
2	Хүнсний үйлдвэр үйлчилгээ	мэдээллийн сан	63	29	34
3	Хүнсний худалдаа	байхгүй байна.	379	69	310
Нийт дүн			559	141	418

Хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн мэдээлэл 74-өөр, Хүнсний үйлдвэр үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн мэдээлэл 34-өөр, Хүнсний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн мэдээлэл 310-аар тус тус зөрүүтэй байна.

Аймгийн ЗДТГ нь дээрх 3-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийн сан бүрдүүлж ажиллаагүй байна.

МХГ-ын хэмжээнд ашиглаж байгаа Шилэн хяналтын цахим хуудсыг ашиглах журам заавар байхгүй, программын зарим мэдээлэл зөрүүтэй байна. Гэвч энэ программуудыг үйл ажиллагаандаа голлон ашиглаж байна.

Аудитын ажиглалтаар аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөөгүй байна. Энэ нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18.1.4¹⁹ дахь заалтын дагуу хяналтаа тавихгүй байгааг харуулж байна.

1.3.6 Шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлээгүй байна.


Хүнсний тухай хуулийн 3.1.5-д "органик хүнс" гэж мал аж ахуй, газар тариалангийн органик үйлдвэрлэлийн болон цэвэр байгалийн гаралтай Монгол Улсын болон олон улсын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүнийг хэлнэ гэж тодорхойлсон.

¹⁹ зохистой дадлыг нэвтрүүлэх болон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлд хяналт тавих


Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, бусад дэд хөтөлбөрүүдэд аймгийн тухайд шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг төлөвлөж оруулаагүй, органик бүтээгдэхүүний тэмдэг, тэмдэглэгээ, шошго тавих зөвшөөрөл авсан хүнсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүн байхгүй. Энэ нь төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4 дүгээр зүйлийн 4.1.18²⁰ дэх заалтын хэрэгжүүлээгүй болохыг харуулж байна.

Дүрслэл №4: Санал асуулгын үр дүн /органик хүнсний талаар/

5. Та өдөр тутмын хоол хүнсэндээ шим тэжээллэг болон органик хүнс сонгон хэрэглэж чаддаг уу?
102 төсөөлөгч



6. Дээрх асуултад үгүй гэж хариулсан бол учир шалтгааныг сонгоно уу.
122 төсөөлөгч



Санал асуулгын дүнгээс харахад: Өдөр тутмын хоол хүнсэндээ органик хүнс сонгон хэрэглэж чадаж байна уу гэсэн асуултад 17 хувь нь үгүй, 54.9 хувь нь заримдаа, 27.5 хувь нь тийм гэж хариулжээ. Үгүй гэж хариулсан шалтгаан нь 41.2 хувь нь олдоц муу байдаг, 23.5 хувь нь органик хүнсний чанар, шимт байдлыг алдагдуулах нөхцөлд худалддаг, 19.6 хувь нь органик хүнс өндөр үнэтэй байдаг, 15.7 мэдлэг мэдээлэл хомс байдаг гэж хариулжээ. Эндээс харахад иргэд олон нийт органик хүнсийг хэрэглэх сонирхолтой байна. Гэвч дотооддоо үйлдвэрлэдэггүй учир гаднаас өндөр үнэтэй, хадгалалтын горим зөрчигдсөн бүтээгдэхүүн авахыг хүсдэггүй байна. Иймд шим тэжээллэг, органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

1.3.7 Зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэгдэж байгаа эсэхэд тавих хяналт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор баталсан "Сав, баглаа боодол" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, биелэлтийг тооцож гаргаагүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.4-т хүнсний бүтээгдэхүүний шошго үйлдвэрлэсэн он, сар, өдөр, тэжээллэг чанар, орц найрлага зэрэг мэдээллийг агуулсан байхаар заасан.

Аудитаар аймгийн хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаатай танилцахад үйлдвэрлэсэн огноог тэмдэглэдэггүй, тэжээллэг чанарын мэдээлэл, хүнсний нэмэлтийн Е тэмдэглэгээ тавьдаггүй, орц найрлагыг тодорхой бичдэггүй зэрэг нь хэрэглэгчийн төөрөлдүүлэх сөрөг үр дагавартай төдийгүй хэрэглэгчийн эрх ашгийг зөрчиж байгаа нэг хэлбэр юм.

Аймгийн ХХААГ-аас 2018 онд ЭМГ-тай хамтран хийсэн судалгаагаар нийт судалгаанд оролцогч 2016 өрхийн 58% нь хүнсний зориулалтын бус хөх, шар сав хэрэглэдэг үр дүн гарчээ.

Хэрэглэгчдэд чиглэсэн зөвлөмж, зөвлөгөө, мэдээ мэдээллийг чанартай, үр өгөөжтэй хэлбэрээр хүргэх, хүнсний зах, худалдааны төв, үйлдвэр, үйлчилгээний газруудыг эрүүл ахуйн шаардлага хангасан стандартын тор, бидон, зориулалтын сав ашиглахыг шаардах, хэрэглээний зөв дадлыг хэвшүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

²⁰ хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлэх

Аудитаар 19 хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд ажиглалт хийхэд жижиглэн савласан бүтээгдэхүүн дээр ХБАБХТХ-ийн 12.4-д заасан мэдээлэл болон шошго, савласан огноог бичээгүй, үйлдвэрлэсэн огноог тэмдэглээгүй 10 ААН байсан.

1.3.8 Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсрол олгох сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүмүүсийн тоо буурсан, энэ талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр дүнгүй байна.

Аймгийн ЭМГ-аас 2018-2020 онд хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол хүнсээ сонгох, хэрэглэх хадгалах, хандлагыг өөрчлөх, хяналт тавих, дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах чиглэлээр дараах ажлыг зохион байгуулжээ.


Хүснэгт №4: Хоол, хүнсний талаарх мэдлэг олгох сургалт, сурталчилгаанд хамрагдалт

Огноо	Сургалтад хамрагдалт		Мэдээлэл зөвлөмж өгсөн хүний хамрагдалт	
	Сургалтад хамрагдсан	Нийт хүн амын тоонд эзлэх хувь	Зөвлөмж өгсөн хүний тоо	Нийт хүн амын тоонд эзлэх хувь
2018	1,069	1.8 %	8,024	13%
2019	2,525	4.4%	900	1.5%
2020	0	0	0	0
дүн	3,594		8,924	

- Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэхээр 2018 онд эмч эмнэлгийн ажилтан, иргэд олон нийтэд 1,069 хүн сургалтыг, 8,024 хүнд сурталчилгаа, заавар зөвлөмжийг хүргүүлж, “Миний нутаг” телевизээр 6 удаагийн мэдээ, 4 төрлийн телевизийн шторк, “Алтай” Олон нийтийн радиод 3 удаагийн мэдээ мэдээллийг
- Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэхээр 2019 онд зөв хооллолт, хоол тэжээлийн талаар сургалтыг 2,500 иргэнд, хаяг шошгын талаар сургалтыг 25 хүнийг хамруулж, 900 хүнд давсны хэрэглээг бууруулах зөвлөмж хүргүүлэн, Миний нутаг телевизээр 6 удаагийн мэдээ, 4 төрлийн телевизийн шторк, Алтай Олон нийтийн радиод 3 удаагийн мэдээ мэдээллийг
- Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэхээр 2020 онд Миний нутаг телевизээр 5 удаагийн мэдээ, “Алтай” Олон нийтийн радиод 5 удаагийн мэдээ мэдээлэл, МонЦаМэ агентлагт 2 удаагийн мэдээлэл, Алтай мэдээ агентлаг цахим хуудсаар 12 төрлийн мэдээллийг нийтлүүлсэн байна.

Дүрслэл №8: Санал асуулга /сургалт, сурталчилгаа/

8. Та төрийн байгууллагаас /эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандарт хэмжээний зүйн газар г.м/ зохион байгуулсан эрүүл...лгох сургалтад сүүлийн 3 жилд хамрагдсан уу?
102 responses



Санал асуулгын дүнгээс харахад: Төрийн байгууллагуудаас хүний эрүүл мэнд, хэрэглэгчийн боловсрол олгох сургалтад сүүлийн 3 жил хамрагдсан уу гэсэн асуултад 88.2 хувь нь үгүй гэж хариулжээ. Иргэдийн хоол хүнсний эрүүл мэндийн талаарх мэдлэг мэдээлэл дутмаг байгаа нь харагдаж байна.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙГААГ ЭС ТООЦВОЛ ГҮЙЦЭТГЭЛ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

2.1 Төсвийг хууль дүрэм журмын дагуу төлөвлөөгүй байна.

2.1.1 Хөтөлбөрт санхүүжүүлэх эх үүсвэрийг нийтлэг байдлаар оруулж төлөвлөсөн байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг ерөнхий байдлаар төлөвлөдөг нь төсөл, хөтөлбөр хангалтгүй хэрэгжих шалтгаан болж байна. Тухайлбал ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн "Үндэсний хөтөлбөр батлах тухай" А-178 дугаар тушаалаар "Малын эмийн үлдэгдлийн хяналт"-ын үндэсний хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталсан. Аймгийн Мал эмнэлгийн газраас боловсруулан хэрэгжүүлж байгаа дэд хөтөлбөрийн хүрээнд эмийн үлдэгдэл бодис тодорхойлох оношлуур, урвалж бодисоор хангагдахаар тусгасан. Малын эмийн үлдэгдлийг илрүүлэх сорил шинжилгээ хийхэд урвалж бодис өртөг өндөртэй, төсөвт тусгагдаагүйгээс тус газрын лаборитарит энэ төрлийн шинжилгээ хийгдээгүй байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн Төмс дэд хөтөлбөрт Чандмань суманд 100 тн-оос доошгүй багтаамжтай зоорийг бариж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Хөтөлбөрийн биелэлтийг үзэхэд ОНХС-гаас хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж хүнсний ногооны зорь барих төлөвлөгөөтэй ажилласан боловч орон нутгийн төсвөөс дэмжлэг авч чадаагүй учраас баригдаагүй байна.

➤ Тендер худалдан авалт

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2021 оны "Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай дотуур байр, хүүхдийн хоол, хүнсний хангамжийн талаар авах арга хэмжээний тухай" А/38 дугаар захирамжаар Есөнбулаг сумын Засаг даргад сумын сургууль, цэцэрлэгийн үдийн хоолны тендер шалгаруулалт хийх эрхийг өгсөн байна. Тендер шалгаруулалт амжилтгүй болж Есөнбулаг сумын Засаг даргаас сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт хичээлийн шинэ жилтэй холбогдуулан өмнөх гэрээт байгууллагуудтай гэрээг сунгах чиглэлийг хүргүүлжээ. Өмнөх гэрээр сунгахдаа махыг зах зээлийн ханшнаас 2000-3000 төгрөгөөр өндөр үнээр худалдан авсан нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах зарчмыг алдагдуулж байна.

Хүснэгт №5: Боловсролын салбарын орон тооны стандарт

№	ЕБС	Багаарын суралцагч тоо	Одоо ажиллаж байгаа		Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу						
			Тогсон	Бэлтгэгч	Холбогч	Тогсон	Бэлтгэгч	Улаач	Үйлдэгч	Нэг орон тоо	
1	Алтай сумын ЕБС	150	1	1	1	2	1	1	1	6	
2	Баян-Уул сумын ЕБС	250	1	1	1	2	1	1	1	6	
3	Бигэр ЕБС	191	1		1	2	1	1	1	6	
4	Бугат ЕБС	178	1	1	1	2	1	1	1	6	
5	Тажийн талын ЕБС	19	1			1	1	1	1	3	
6	Дарив ЕБС	173	1		1	2	1	1	1	6	
7	Дэлгэр ЕБС	182	1	1	1	2	1	1	1	6	
8	Гуулин ЕБС	57	1			1	1	1		3	
9	Жаргалан ЕБС	77	1	1		1	1	1		3	
10	Тайшир ЕБС	57	1			1	1	1		3	
11	Тонхил ЕБС	214	2	1	1	2	1	1	1	6	
12	Тонхил ЕБС Алтансөмбө	14				1	1	1		3	
13	Төгрөг ЕБС	160	2	1	1	2	1	1	1	6	
14	Халиун ЕБС	88	1	1		1	1	1		3	
15	Олонбулаг ЕБС	11	1			1	1	1		3	
16	Хөхморьт ЕБС	193	3		1	2	1	1	1	6	
17	Цогт ЕБС	226	1			2	1	1	1	6	
18	Цогт Баянтоорой ЕБС	128	2	1	1	2	1	1	1	6	
19	Цэцэг ЕБС	209	2		1	2	1	1	1	6	
20	Чандмань ЕБС	202	1			2	1	1	1	6	
21	Шарга ЕБС	124	2	1	1	2	1	1	1	6	
22	Эрдэнэ ЕБС	197	1			2	1	1	1	6	
23	1-р сургууль	1003	2	2	1	2	1	1	1	6	
24	2-р сургууль	406	2	1	1	2	1	1	1	6	
25	3-р сургууль	544	2	1	1	2	2	1	1	7	
26	4-р сургууль	352	1	2	1	2	1	1	1	6	
27	ХЭЦ сургууль	336	2	1	1	2	1	1	1	6	
	Бүгд	5739	37	17	20	47	28	27	20	142	

УИХ-аас 2019 онд батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн дагуу 2021-2022 оны хичээлийн жилд аймгийн 27 Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа 1-5 дугаар ангийн 5739 хүүхэд үдийн хоолны үйлчилгээнд хамруулж байна.

/Эх сурвалж: аймгийн БСУГ-ын статистик мэдээ/

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу сургуульд нэмэлт орон тоо шаардлагатай тооцоо гарч байна. Хуульд зааснаар сургууль бүрд хоол зүйч ажиллуулахаар байгаа ч аймгийн хэмжээнд мэргэжлийн хоол зүйчтэй сургууль байхгүй, сургуулийн эмч, тогооч, захирал, нягтлан бодогч нар хамтран хоолны цэс боловсруулж байна.

Үдийн хоол хөтөлбөрийн бодит нөхцөл байдлыг судалж үзэхэд стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангагдаагүй, тогоочийн ажлын ачаалал харилцан адилгүй, Мөн Бугат сумын Тахийн талын ЕБС /Үйлчлэгчийн орон тоонд тогооч ажиллуулж байгаа/, Тонхил сумын Алтансоёмбо багийн ЕБС-дад тогоочийн орон тоо батлагдаагүйн улмаас тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж байна.

2.1.2 Зорилт, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөхдөө хэрэгцээ, шаардлага, үр ашгаар эрэмбэлээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор ОНХС-гийн эх үүсвэрээр “Газар тариалан, жимс жимсгэнэ” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2,000,000.0 мянган төгрөгийг батлахдаа иргэдээс санал авч, үр ашгаар эрэмбэлээгүй нь Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны” журмыг зөрчсөн байна.


2.2 Төсвийн гүйцэтгэл үр дүнтэй боловч түүнд тавих хяналт сул байна.

2.2.1 Хөтөлбөрт хүрээнд ЖДҮ-г дэмжихээр олгосон зээлийг ихэнх иргэн, ААНБ зориулалтын дагуу зарцуулж байгаа боловч, эргэн төлөлт удаашралтай байна.

✚ Сум хөгжүүлэх сан:

ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам” батлагдсан. СХС-гийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: СХС-гийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулахаар журамлагдсан байна.

Дүрслэл №9: СХС-гаас зээл авсан иргэн, ААНБ-ын зориулалт /салбараар/



СХС-аас хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар 2018-2020 онд 153 иргэн, ААН-д 1,025,495.0 мянган төгрөгийн зээлийг олгосон байна. Зээлийг зориулалтаар нь авч үзвэл нийт зээлдэгчдийн 54% нь 550,895.0 мянган төгрөгийг хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээр, 21% буюу 211,000.0 мянган төгрөгийг газар тариалан эрхлэх чиглэлээр, 17% буюу 178,100.0 мянган төгрөгийг сүү,

цагаан идээ боловсруулах, 8% буюу 85,500.0 мянган төгрөгийг мал, аж ахуй эрхлэх зориулалтаар олгосон байна. Нийт зээлдэгчийн 8% буюу 22 иргэн, ААН 80,887.6 мянган төгрөгийг зээлийн гэрээт хугацаанд төлөөгүй байна. /Эх сурвалж: Төрийн аудитын газрын статистик мэдээ 2021.10.01-ний байдлаар/

Аудитаар зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгааг холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авч хянахад: зээлийн гэрээт хугацаа дуусаагүй байхад 11 зээлдэгч зориулалтын дагуу зарцуулахгүй буюу үйл ажиллагаа явуулаагүй байна.

✚ Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан:

ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас хүнсний чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 18 иргэн, ААНБ-д 957,250.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгожээ. ХХААХҮЯ-ны ЖДҮ-ийн газраас 2021 онд зээлийн, хяналт мониторинг хийж төслийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгааг тайланд дурдсан байна. Аудитаар тус сангаас зээл авсан 5 иргэн, ААН-ийн үйл ажиллагаатай танилцаж зээлийг зориулалт бусаар зарцуулсан байж болзошгүй 1 ААН-ийн мэдээллийг холбогдох газарт уламжлахаар шийдвэрлэсэн.

📌 Тариалан эрхлэлтийг дэмжих сан:

ТЭДС нь аймгийн ИТХ-ийн 2015 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих тайлагнах журам”-аар зохицуулагдаж байна.

ТЭДС-ийн үйл ажиллагаа нь усалгаатай газар тариаланг хөгжүүлэх, услалтын систем байгуулах, сэргээн засварлах тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах нөхөн сэргээх таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх хөдөө аж ахуйн техник технологийн шинэчлэлт хийх үрийн нөөц бүрдүүлэх жижиг зээл олгох, үүссэн өр авлагыг барагдуулахад зориулан зарцуулахаар журамлагдсан байна.

Аймгийн ТЭДС-гаас 2018-2019 онд 39 иргэн, ААН-д 83,218.5 мянган төгрөгийг үрийн төмс, хүлэмж, мөнгөн зээл хэлбэрээр олгосон байна. Үүнээс 5,915.5 мянган төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн, төлөгдөөгүй байна. ТЭДС-гаас зээл, үр худалдан авсан зээлдэгчдээс өмнөх онуудад барагдвал зохих авлагыг төлүүлээгүй, 2020 оны санхүүгийн тайлангаар нийт авлагын үлдэгдэл 132,153.7 мянган төгрөг байгаа нь сангийн хөрөнгийн эргэлтийг бууруулж, сангийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд эх үүсвэр дутагдах эрсдэлд хүргэж байна.

📌 Аймаг, сумын Орон нутаг хөгжүүлэх сан:

Төсвийн тухай хуульд зааснаар ОНХС-гийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг баримтлан үйл ажиллагаагаа явуулдаг.

Сумдын ОНХС-аас 2018-2020 онд 38,923 мянган төгрөгийг хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд буюу сумын төвийн ундны усны худгийн засвар, газар тариалангийн тоног төхөөрөмж, үр нийлүүлэх зэрэг зардалд зарцуулжээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор ОНХС-гийн эх үүсвэрээр “Газар тариалан, жимс жимсгэнэ” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2,000,000.0 мянган төгрөгийг баталсан. Аудитаар тус хөтөлбөрийн гэрээ, ажил хүлээж авсан акт, зарцуулалтын баримтыг хамруулан шалгахад дараах зөрчил илэрсэн:

- Газар тариалан, жимс жимсгэнэ хөтөлбөрийн Багц-1 Ойн зурвасын суулгац нийлүүлэх гэрээгээр хүлээлгэж өгсөн суулгац 1,496.0 мянган төгрөгөөр дутуу байна.
- Газар тариалан, жимс жимсгэнэ хөтөлбөрийн Багц-1 Ойн зурвасын суулгац тараасан зарлагын баримт 1,328.0 мянган төгрөгөөр, Багц-2 Жимс жимсгэнэний суулгац тараасан зарлагын баримт 7,624.0 мянган төгрөгөөр илүү, Багц-3 Үр тараасан зарлагын баримт 2,093.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.
- Газар тариалан, жимс жимсгэнэ хөтөлбөрийн Багц-4 Алтай, Жаргалан сумдад зуны хүлэмж нийлүүлэх, Багц 5-Бигэр, Жаргалан сумдад дуслын услалтын систем нийлүүлэх, Багц 7-Услалтын систем засварлах, Багц 8-Бугат, Жаргалан,

Хөхморьт сумдад инженерийн хийцтэй гүний худаг гаргах ажлын гэрээт хугацаа дууссан боловч комисс хүлээж авсан эсэх нь тодорхой бус байна.

Хүнс хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн хүнсний зоорины судалгаанаас харахад нийт 47 зоорины 13 нь төсвийн байгууллагын эзэмшилд байгаагаас 9 нь хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалтаар бус өвс тэжээл, хөрөнгө хадгалах агуулах хэлбэрээр ашиглагдаж байна. /Хавсралт №3/

Төсвийн гүйцэтгэлд тавих хяналт үр дүнгүй байна.

Төсөл, хөтөлбөр, тусгай сангуудын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байгаа боловч хяналт үр дүнгүй байгааг дараах асуудлууд болно. Үүнд:

- Газар тариалан, жимс жимсгэнэ хөтөлбөрийн Багц-1, 2, 3 буюу Аймгийн ОНХС-ын дэмжлэгт хамрагдсан газар тариалан эрхлэгчидтэй хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулалтын дагуу зарцуулах, үр дүнтэй ажиллах гэрээнд оролцогч талуудын эрх үүргийг тодорхой тусгаагүй байгаа нь хөрөнгө оруулалтад тавих хяналт, үр ашгийг бууруулах эрсдэлийг үүсгэж байна.
- Аймгийн ХХААГ-т 2018 онд "Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн 106,665.6 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг иргэн, ААН-д ашиглуулахдаа хүлээлцсэн акт үйлдээгүй, тоног төхөөрөмж түрээслүүлэх гэрээний хугацаа дууссан байхад ямар нэгэн арга хэмжээ аваагүй, тооллого тооцоо бодоогүй байна.

Аудитын явцад махны үнэ өндөр байгаатай холбоотой санал ирүүлсний дагуу судалж үзэхэд: Говь-Алтай аймгийн Засаг даргын 2021 оны "Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай дотуур байр, хүүхдийн хоол, хүнсний хангамжийн талаар авах арга хэмжээний тухай" А/38 дугаар захирамжаар Есөнбулаг сумын Засаг даргад Есөнбулаг сумын сургууль, цэцэрлэгийн үдийн хоолны тендер шалгаруулалт хийх эрхийг өгсөн байна. Тендер шалгаруулалт амжилтгүй болж Есөнбулаг сумын Засаг даргаас сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт хичээлийн шинэ жилтэй холбогдуулан өмнөх гэрээт байгууллагуудтай гэрээг сунгах чиглэл хүргүүлжээ. Өмнөх гэрээр сунгахдаа махыг зах зээлийн ханшнаас 2000-3000 төгрөгөөр өндөр үнээр худалдан авсан нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах зарчмыг алдагдуулж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.²¹ дэх заалтыг зөрчсөн байна.

Зураг №10: ХХҮГ-ын зоорь



Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар нь 2018 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр 16,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 250м² улирлын хүлэмжийг бүлгийн зохион байгуулалтаар хүнсний ногоо тариалах, өрхийн амьжиргааг дэмжих зориулалтаар барьсан ч өнөөдрийг хүртэл ашиглалтгүй байна.

²¹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ:

1. Хэвийн боов MNS 0461-1981, жигнэмэл гурилан бүтээгдэхүүн 2488-1999 стандартыг шинэчлэн батлах шаардлагатай байна.
2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5^{1.2}, 5^{3.3} дахь заалтаар 5 ба 2 хоногийн өмнө шалгагдагч этгээдэд урьдчилан мэдэгдэж байгаа нь зөрчлийг нуун дарагдуулах шалтгаан болж байна.
3. Тухайн нутаг дэвсгэрт хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллаагүй байна.
4. Есөнбулаг сумын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн орон тоонд төрийн албаны шалгалтад тэнцээгүй ажилтныг авч ажиллуулснаас улсын байцаагчийн албан тушаалын бүрэн эрхийг хэрэгжүүлж чадахгүй байна
5. МХГ нь "Шинэ-Алтай" захын лабораторийн үйл ажиллагаанд 2006 оноос хойш хяналт тавьж ажиллаагүй байна.
6. МХЕГ-ын удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 44 объектоос хэрэглээний баталгаат хугацаа дууссан 9,466.9 мянган төгрөгийн 6,271 ширхэг бүтээгдэхүүн хураан авснаас 12 объектод 3,800.0 мянган төгрөгийн зөрчлийн хэрэг үүсгэн торгууль ногдуулсан ба 10 ААНБ хүсэлтээр ирүүлэн, үлдсэн 22 объектод ямар арга хэмжээ авсан нь тодорхойгүй байна
7. Аймгийн хэмжээнд болзошгүй үед хэрэгжүүлэх нөөцийн асуудлыг шийдвэрлээгүй, арга хэмжээ аваагүй байна.
8. "Шинэ-Алтай" зах ХХК-ны лаборатори нь 2006 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд итгэмжлэлгүй, стандартын шаардлага хангахгүй байхад үйл ажиллагаа явуулан 2018-2020 онд 34,924.3 мянган төгрөгийн шинжилгээний төлбөрийг хууль бусаар олж, эрүүл ахуйн шаардлага хангахгүй орчинд ил задгай худалдаалагчдыг дэмжин, түүнээсээ ашиг хүртэж байгаа энэ үйл ажиллагаа нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.
9. "Шинэ-Алтай" зах ХХК-ны лабораторийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй, ажлын байрны тодорхойлолтод нийцээгүй албан тушаалтныг авч ажиллуулсан
10. МХГ-ын лаборатори нь 2018-2020 онд 1,755.3 мянган төгрөгийн шинжилгээний төлбөрийг дутуу тооцож авсан байна.
11. Аймгийн ХХААГ-аас ирүүлсэн хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгаанд үндэслэн тооцоход 77 нэр төрлийн бүтээгдэхүүн Тохирлын үнэлгээнд хамрагдаагүй, хамрагдсан бүтээгдэхүүний тохирлын үнэлгээний хүчинтэй хугацаа дууссан байна.
12. Аудитаар түүвэрчлэн авч үзэхэд аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөөгүй байна.
13. Шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлээгүй байна.
14. Аудитаар 19 хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд ажиглалт хийхэд жижиглэн савласан бүтээгдэхүүн дээр ХБАБХТХ-ийн 12.4-д заасан мэдээлэл болон шошго, савласан огноог бичээгүй, үйлдвэрлэсэн огноог тэмдэглээгүй, орчин нөхцөл эрүүл ахуйн шаардлага хангахгүй, ажиллагсад эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан дэвтэргүй, хөргөгч, хөлдөөгчийн температурын заалтыг хянаж бүртгэл хөтөлдөггүй, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл өмсөж хэвшээгүй, хугацаа нь дууссан бүтээгдэхүүн худалдан борлуулж байлаа.

15. Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгүй байна.
16. Есөнбулаг сумд согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо норматив хэмжээнээс 27-оор илүү, Чандмань сумд 2-оор илүү байна.
17. Газар тариалан, жимс жимсгэнэ хөтөлбөрийн Багц-1 Ойн зурвасын суулгац нийлүүлэх гэрээгээр хүлээлгэж өгсөн суулгац 1,496.0 мянган төгрөгөөр дутуу байна.
18. Газар тариалан, жимс жимсгэнэ хөтөлбөрийн Багц-1 Ойн зурвасын суулгац тараасан зарлагын баримт 1,328.0 мянган төгрөгөөр, Багц-2 Жимс жимсгэнийн суулгац тараасан зарлагын баримт 7,624.0 мянган төгрөгөөр илүү, Багц-3 Үр тараасан зарлагын баримт 2,093.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.
19. Газар тариалан, жимс жимсгэнэ хөтөлбөрийн Багц-4 Алтай, Жаргалан сумдад зуны хүлэмж нийлүүлэх, Багц 5 - Бигэр, Жаргалан сумдад дуслын услалтын систем нийлүүлэх, Багц 7-Услалтын систем засварлах, Багц 8-Бугат, Жаргалан, Хөхморьт сумдад инженерийн хийцтэй гүний худаг гаргах ажлын гэрээт хугацаа дууссан боловч комисс хүлээж авсан эсэх нь тодорхой бус байна.
20. "Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХХААГ-т нийлүүлсэн 106,665.6 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг иргэн, ААН-д ашиглуулахдаа хүлээлцсэн акт үйлдээгүй, тоног төхөөрөмж түрээслүүлэх гэрээний хугацаа дууссан байна.
21. Есөнбулаг сумын сургууль цэцэрлэгийн үдийн хоолны тендер амжилтгүй болсноос махыг зах зээлийн ханшнаас өндөр үнээр худалдан авч байна.
22. ХХААЯ-аар дамжуулан ЖДҮХС-гаас зоорины аж ахуй эрхлэхээр 148,000.0 мянган төгрөгийн зээл авсан "Хярын улаан" ХХК-ийн үйл ажиллагаатай танилцахад 60тн-ын зоорийг бэлтгэн, 100,000.0 мянган төгрөгийг "Хүрийн овоо" ХХК-д хөрөнгө оруулсан гэх боловч гэрээ хэлцэл байгуулаагүй зориулалт бусаар ашиглаж байн

Дээрх дүгнэлтэд үндэслээд дараах шийдвэрийг гаргаж байна.

Санал уламжлах тухай:

Үндэсний аудитын газарт

1. Хэвийн боов MNS 0461-1981, жигнэмэл гурилан бүтээгдэхүүн 2488-1999 стандартыг шинэчлэн батлах асуудлыг холбогдох газарт уламжлах
2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5^{1.2}, 5^{3.3} дахь заалтыг шинэчлэх талаар холбогдох газарт уламжлах
3. Ажлын байрны тодорхойлолтод нийцэхгүй ажилтныг авч ажиллуулан улсын байцаагчийн эрх үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаа асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэхийг ТАЗ-д уламжлах
4. Албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Говь-Алтай аймгийн МХГ-ын дарга Н.Сумъяабазарт сахилгын хариуцлага ногдуулах
5. Ажиллагсдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зөвлөн туслах арга хэмжээ зохион байгуулахыг МХЕГ-т уламжлах
6. Хууль зөрчин иргэдийн эрүүл мэндэд аюул учруулж байгаа "Шинэ-Алтай" захын лабораторийн үйл ажиллагааг хуулийн байгууллагад шилжүүлэх
7. Ажил албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Говь-Алтай мал эмнэлгийн газрын дарга Д.Наянбууд сахилгын хариуцлага ногдуулах

8. ЖДҮ-ээс авсан зээлийн зориулалт үйл ажиллагаанд хяналт хийж асуудлыг шийдвэрлэхийг ХХААЯ-ны дотоод аудитын газарт уламжлах

Зөвлөмж:

Аймгийн ИТХ-ын дарга Д.Даваадорж танаа

1. Хүнсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ТББ-уудтай хамтран ажиллах

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар

1. Шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг түлхүү нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах

Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагважаргал

1. Иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, иргэд олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах

Албан шаардлага:

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар

1. Стратегийн улирлын хүнсний нөөц бүрдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах
2. Согтуулах цэгийн тоог хууль, тогтоомж жишиг нормативаас хэтрүүлэхгүй байхаар цаашид тооцох
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллах

Мэргэжлийн хяналтын газрын дарга Н.Сумъяабазар

1. Ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөлтөд хяналт тавьж ажиллах
2. Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгааг хийж тохирлын үнэлгээнд хамрагдсан эсэхэд хяналт тавьж ажиллах
3. Дээрх объектуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж үр дүнг тооцон биелэлтийг ирүүлэх

Хүнс хөдөө аж ахуйн газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Т.Сүхбаатар

1. Төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй хөрөнгийн биет тооллогыг хийж үр дүнг тооцож биелэлтийг ирүүлэх

Аймгийн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батзориг, Хүнс хөдөө аж ахуйн газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Т.Сүхбаатар

1. Зарлагын баримт зөрүүтэй, гэрээний хугацаа дууссан боловч хүлээж аваагүй байгаа төсөл хөтөлбөрийн гэрээний хэрэгжилтийг үнэлэх

Төлбөрийн акт:

Мэргэжлийн хяналтын газрын дарга Н.Сумъяабазар

1. Дутуу тооцож авсан шинжилгээний төлбөр 1,755.3 мянган төгрөгийг төлүүлэх

Аймгийн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батзориг, Хүнс хөдөө аж ахуйн газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Т.Сүхбаатар

1. Дутуу ирсэн суулгацын 1,496.0 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн дансанд төвлөрүүлэх

Холбогдох байгууллагын санал, түүнд өгсөн хариу тайлбар

Холбогдох байгууллага	Ирүүлсэн санал	Хариу тайлбар
1 Аймгийн ИТХ	Саналгүй гэсэн албан тоот ирүүлсэн	Тайлбар шаардлагагүй
